



ОНЦГОЙ БАЙДЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 1/01

Улаанбаатар хот

Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх
зарим арга хэмжээний тухай

Жил бүрийн хавар, намрын хуурайшилтын улиралд ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрч улс эх орон, нийгэм эдийн засагт ихээхэн хэмжээний хохирол учруулсаар байна.

Улсын хэмжээнд 2019 онд нийслэл Улаанбаатар хот, Архангай, Хэнтий, Дорнод, Сэлэнгэ, Хөвсгөл, Булган, Төв, Увс, Завхан, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Баян-Өлгий, Сүхбаатар зэрэг 15 аймгийн 66 суманд ой, хээрийн түймэр 121 удаа гарч 311.798 га талбай түймэрт өртөж, 13 байшин, 4 гэр шатаж, түймрийн улмаас байгаль экологид 23.756.621.096 мянган төгрөг, түймрийг унтраахад 449.625.850 төгрөгийн зардал гарч, нийт 24.206.246.946 төгрөгийн хохирол учирсан байна.

2019 оны Улсын онцгой комиссын 01 дүгээр албан даалгаврын хүрээнд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг шуурхай зохион байгуулснаар ой, хээрийн түймрийн шатсан талбай 2018 онтой харьцуулахад 45.2 хувиар, нийт учирсан хохирол 38.8 хувь буурсан байна.

Цагдаагийн байгууллага 2019 онд 121 удаагийн ой, хээрийн гал түймрийн 22 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 32 мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 53 мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, 14 хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулсан байна.

Цаг уур, орчны шинжилгээний газраас цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээллээр Увс, Завханы хойд болон зүүн, Хөвсгөлийн баруун, Баянхонгорын хойд хэсгээр 11-17 градус, Ховд, Говь-Алтай, Өвөрхангай, Дундговийн өмнөд хэсэг, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутгаар 2 градус, нийт бүс нутгаар 4, 5, 6 дугаар саруудад олон жилийн дунджаас 1.0-1.5 градус дулаарч, хур тунадас багатай, хуурайшилтын зэрэг өндөр байх мэдээлэл ирүүлсэн.

Иймд Улсын онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах, ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын
дарга нарт ДААЛГАХ нь:

1. Ойн тухай хуулийн 17, 18, 26 дугаар зүйлд заасны дагуу ой, хээрийн гал түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх төлөвлөгөө, төсвийг бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг тайланд тусгахыг;
2. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.19, Ойн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн ой, хээрийн гал түймэр унтраахад дайчлах гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах тэдгээрийг ой, хээрийн гал түймрийн үед үүрэг

гүйцэтгэх дадлага, чадвартай болгох зорилгоор сургалт, дадлага зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхийг;

3. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйл, 10.2.4, 10.3 дугаар зүйлд заасныг үндэслэн аймаг, дүүргийн хэмжээнд гарсан ой, хээрийн гал түймрийн хохирлыг бууруулах зорилгоор сум, хороонд байгуулагдсан "Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг"-т тодотгол хийх, шаардлагатай сум, хороонд нэмэлт хэсэг байгуулахыг;

4. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2012 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад галт зэвсэг, галт хэрэглэл хадгалах, хамгаалах, ашиглах журам"-ын дагуу түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх үед өөрийгөө болон бусдыг хамгаалах зорилгоор галт зэвсэг ашиглах боломжийг бүрдүүлэх;

5. Монгол Улсад коронавируст (COVID-19) халдварын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан Улсын Онцгой Комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэлийн 3.1 дэх хэсэгт Хөдөлмөрийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.2-т заасныг мөрдлөг болгон хүн хүч, техник хэрэгслийг дайчлан гарсан ой, хээрийн гал түймрийг шуурхай унтраах арга хэмжээг зохион байгуулах;

6. Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 120 дугаар тушаалаар батлагдсан зааврын дагуу аймаг, нийслэлийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд тодотгол хийхийг;

7. Ой, хээрийн гал түймрийн эрсдэл бүхий орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, жуулчны бааз зэрэг үйлчилгээний байгууллагуудад гал түймрийн улсын хяналт шалгалтыг зохион байгуулах, ой, хээрийн гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангуулах, түймэр тархахаас урьдчилан сэргийлэх зурвас шинээр байгуулах, зурвасыг сэргээхийг;

8. Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт технологи ашиглах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, албаны бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэхийг;

9. Алба хаагчид болон ой, хээрийн гал түймэрт дайчлагдан ажиллах томилгоот иргэдийн хувийн аранз, гар багаж, автомашин, техник, тоног төхөөрөмж, бүх төрлийн багаж хэрэгслийн засвар үйлчилгээг хийж, аюулгүй найдвартай ажиллагааг хангах, шаардлагатай сэлбэг, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангуулахыг;

10. Ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг байршил тодорхойлогч /GPS/, сансрын холбооны утас /IRIDIUM/ болон байр зүйн зургаар хангаж, түймрийн голомтод очсон даруй газар орон, цаг агаарын нөхцөл байдал, түймрийн шатлагын талбай, /га/ солбицлыг үнэн зөв, шуурхай тодорхойлж мэдээлэхийг;

11. Онцгой байдлын байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн 5 дугаар бүлгийн 4.28-т заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн түймэрт ажиллах бие бүрэлдэхүүнийг байршлаа мэдээлэх, дуут дохио, гэрэлт пуужин, (дуурайлган үзүүлэх хэрэгсэл утаат шашки) хэрэгслээр алба хаагч бүрийг хангах, нөөц бүрдүүлэхийг;

12. Гал түймрийн голомтод ажиллах 1 бүлгийг 12 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулан офицероор ахлуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмээр зааварчилгаа өгөхийг;

13. Орон нутгийн Эрүүл мэндийн байгуулагатай хамтран 25 хүн тутамд 1 эмч томилгоожуулах шийдвэрийг Засаг даргын шийдвэрээр гаргах, унтраах ажиллагаанд алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор оролцуулахыг;

14. Хавар, намрын хуурайшилтын улирал 03 дугаар сарын 20-оос 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-оос 11 дүгээр сарын 10-ны хооронд болон зуны хэт халалтын үед бүс нутгийн түймрийн аюулын ангилал, зэрэглэлийг үндэслэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран аж ахуйн нэгж, байгууллага, иргэний үйл ажиллагаа, ногоон бүсэд зорчихыг тодорхой хугацаагаар хязгаарлахыг;

15. Ойн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалтыг хэрэгжүүлэн ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тогтоох Засаг даргын шийдвэрийг гаргуулан түймэр унтарснаас хойш 30 хоногийн дотор зохион байгуулахыг;

16. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх үед сахилга бат, захирах захирагдах ёс журмыг чанд баримтлан, архи согтууруулах зүйл авч явах, ашиглахыг бүрэн хориглох, цэргийн дүрмийг сахин биелүүлэхийг;

17. Төв, орон нутгийн телевиз, радио, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчныг ашиглан хавар, намрын хуурайшилтын улирал, зуны хэт халалтын үед иргэд, олон нийтэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах чиглэлээр сэрэмжлүүлэг, сурталчилгаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахыг.

Хоёр. Үндэсний аврах бригадын захирагчид ДААЛГАХ нь:

1. Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар гарч ажиллах алба хаагчдын албаны болон хувийн бэлтгэл, бэлэн байдлыг бүрэн хангуулах, шүхрийн зааварлагч, шүхэрчин гал сөнөөгчдийн шүхрийн буултын дадлагыг зохион байгуулахыг;

2. Гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангуулах, техник хэрэгсэлийн засвар үйлчилгээг тогтмол хийж, шаардлагатай сэлбэг, шатах, тослох материалаар тасралтгүй хангаж, нөөцийг бүрдүүлэн, жолооч, автомашин техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулахыг.

3. Ой, хээрийн гал түймрийг шуурхай илрүүлэх, унтраах сургалт, дадлагыг зохион байгуулж, нисгэгчгүй нисдэг төхөөрөмжийг унтраах үйл ажиллагаанд тогтмол ашиглахыг;

4. Дотоод нөөц бололцоонд тулгуурлан ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглах, инновацыг нэвтрүүлэхийг;

5. Ой, хээрийн гал түймэр унтраах үед хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулахыг тус тус даалгаж байна.

Албан даалгаврын биелэлтийг тайланг 2020 оны 06 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор нэгтгэн дүгнэж, танилцуулахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Г.Ариунбуян)-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т БАДРАЛ